



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Стратегийн удирдлагын газар

Ажлын тайлан
2020 оны эхний хагас жил

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл	3
Хоёр. Удирдлага, зохион байгуулалт	3
▪ Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн хураангуй	4
Гурав. Бодлого, төлөвлөлт, судалгаа	5
Дөрөв. Аудитыг дэмжих ажил, үйлчилгээ	10
Тав. Мэдээлэл, технологийн хөгжил	11
Зургаа. Аудитын стандарт, арга зүйн асуудал	12
Долоо. Төрийн аудитын байгууллагын сургалт, хөгжил	14
Найм. Бусад ажил, үйлчилгээ, дотоод үйл ажиллагаа	15
Ёс. Дүгнэлт	17
Арав. Цаашдын зорилт, анхаарах асуудал	18

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2019 оны 6 дугаар
Улаанбаатар
сарын 30-ны өдөр

ХОТ

Нэг. Ерөнхий зүйл

Стратегийн удирдлагын газар /СУГ/ Төрийн аудитын байгууллага /ТАБ/-ын 2019-2024 онд хэрэгжүүлэх стратегийн болон 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд газрын төлөвлөгөөг боловсруулан Монгол Улсын ерөнхий аудитор /МУЕА/-аар батлуулан үйл ажиллагаагаа явууллаа.

СУГ-ын 2020 оны үйл ажиллагааны гол зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор **“Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”**-ийг эцэслэн боловсруулах хууль санаачлагчид хүргүүлэх хууль тогтоомжийн дагуу холбогдох судалгааг хийж, санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, УИХ-ын гишүүдэд танилцуулах, мэргэжлийн онцлогийг тайлбарлах, хууль батлуулахад оролцох, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага /АДБОУБ/-аас гаргасан аудитын стандартыг хянаж дуусган мэргэжлийн байгууллагаар уг **“Төрийн аудитын стандартыг батлуулах”** арга хэмжээг хэрэгжүүлж “хууль” болон “стандарт” батлуулахад оролцоо, чиг үүргийн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлт хангагдлаа.

МУЕА-ын 2020 оны А/02 дугаар тушаалын дагуу тус газар нь үндсэн чиг үүргийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовн шууд удирдлага дор үйл ажиллагаагаа эрхлэн ТАБ-ын стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилгоор аудитын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны асуудлаар санал бэлтгэх, аудитын стандарт, дүрэм, журам, заавар, аргачлал, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, мэдээллийн технологийн бодлого, төлөвлөлт, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Газрын 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны товч тайланг үндсэн чиг үүргийн хамрах хүрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үндэслэн нэгтэн боловсрууллаа.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

СУГ нь ТАБ-ын хэмжээнд хэрэгжих гүйцэтгэлийн баримт бичгийг удирдлага, газрын бүтэц, чиг үүргийн дагуу үйл ажиллагаа, хүний нөөц, төлөвлөгөөт ажлын хэрэгжилтэд удирдлага, зохион байгуулалтыг чиглүүлэн ажиллав.

СУГ-ын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, үр дүнгийн үзүүлэлтийн дагуу албан хаагч бүрээр төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ирсэн бөгөөд оны эхний хагас жилд төлөвлөгөөт ажлын болон ҮАГ-ын Удирдлагын шуурхай хуралдаанаас өгөгдсөн чиглэл, үүргийг бүртгэн хэрэгжилтийг тооцож, тайлагнаж ирлээ.

СУГ нь хүний нөөцийн хувьд нийт 10 ажилтны орон тоотой ажиллахаас 10 ажилтан, цахим сургалт хариуцсан 1 гэрээт ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Цаг үеийн асуудлаар газрын хурал 13 удаа зохиогдож, үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүрд нь хариуцсан ажилтан бүр хэрэгжүүлж, хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн Тамгын газрын олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан шинжээчид хүлээлгэн өгч ирлээ.

Тайлант хугацаанд нийт 95 албан бичиг ирснээс хариутай 23, үйл ажиллагаанд ашиглагдах 72 албан бичиг ирж шийдвэрлэсэн байна. Хариу албан бичиг, мэдээлэл өгөх, хамтран ажиллах тухай, хүсэлт, судалгаа, санал, тайлан, мэдээлэл хүргүүлэх зэрэг 29 албан бичиг боловсруулж хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн хураангуй

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг үндэслэн газрын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн баталсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр зорилт болох “Төрийн аудитын бодлого, төлөвлөлт, стандарт арга зүй”-н хүрээнд 36 /6 дэд арга хэмжээ/ арга хэмжээ, “Хүний нөөц, сургалт, сурталчилгаа”-ны хүрээнд 10 арга хэмжээ, “Аудитын дэмжих үйлчилгээ”-ний хүрээнд 12 арга хэмжээ, “Стратегийн удирдлагын газрын дотоод ажил”-ын хүрээнд 10 арга хэмжээ, нийт 68 арга хэмжээ төлөвлөсөн байна. (Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав)

СУГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзвэл:

- Эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн буюу хэрэгжсэн 30 арга хэмжээ;
- Хэрэгжиж байгаа 19 арга хэмжээ;
- Төлөвлөсөн ажлыг эхлэх хугацаа болоогүй 14 арга хэмжээ;
- Төлөвлөгдсөн хугацааг хойшлуулсан 5 арга хэмжээ байна.

Төлөвлөгөөт арга хэмжээнээс хугацаа хойшлуулсан 5 арга хэмжээ:

1. Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангахтай холбоотой батлагдсан стратегийн хүрээнд Аудитын иргэний танхим болон Аудитын иргэний бүлгийн үйл ажиллагааг зохицуулж, гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт хийх,
2. Төрийн бус байгууллага, хүрээлэн, зөвлөх инженер нартай хамтран ажиллах 2020 оны төлөвлөгөө батлуулах, уг төлөвлөгөөний дагуу уулзалт-семинар зохион байгуулах,
3. Харилцагч талуудын үзэл бодол, хүлээлтэд дүн шинжилгээ хийх,
4. “АДБ-ын Гүйцэтгэлийн хэмжүүрийн үзэл баримтлал, стратегийн төлөвлөгөө, тайлагнал”-ын үе шаталсан хөтөлбөрийн хүрээнд ТАБ-ын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах,
5. Үндэсний аудитын газраас ҮСХ-той байгуулсан “Хамтран ажиллах төлөвлөгөө”-нд тусгасан ажил үйлчилгээний хэрэгжилтийг хангах.

Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд болон бусад ажил, үйлчилгээний чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв.

- Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар чиг үүргийн хүрээний асуудлаар шинээр гүйцэтгэсэн болон МҮЕА, газрын удирдлагын шийдвэр, шууд удирдлага дор нэмэлт “16” ажил, үйлчилгээг гүйцэтгэж үр дүн хангагдсан байна.
- Дотоод ажлын хүрээнд нэмж гүйцэтгэсэн төлөвлөгөөт бус ажил, үйлчилгээ: Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй болон удирдлагын зохих шийдвэрийн дагуу нэмэлт “4” ажил гүйцэтгэж үр нөлөө хангагдсан байна.
- Тайлант хугацаанд зайлиггүй шаардлага болон цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “8” ажлыг нэмж гүйцэтгэсэн нь зохих хэмжээнд үнэлэгдэж үр дүн гарлаа.

Газрын 2019 оны үйл ажиллагаатай холбоотой 16 боть баримт материалыг архивд өглөө.

- Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн баримт 3 боть,
- ТАБ-ын 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагналын баримт материал 2 боть,
- СТАУС-тай холбоотой 3 боть,
- Санхүүгийн аудиттай холбоотой 2 боть,
- Төрийн аудитын байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайлан, статистикийн мэдээллийн 6 боть баримт материалыг журмын дагуу цэгцлэн Тамгын газарт хүлээлгэн өгчээ.

Гурав. Бодлого, төлөвлөлт, судалгаа

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/02, А/20 дугаар тушаалын дагуу ТАБ-ын 2020 оны болон газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулж ажиллав.

Төрийн аудитын байгууллага дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги болон хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх үйл ажиллагааныхаа цаашдын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2020 оныг “Төрийн аудитын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” болгосон эхний хагас жилд бид бүхэн дараах гол баримт бичгийг батлуулахад хувь нэмрээ оруулан ажиллалаа.

“Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, хууль санаачлагчид өргөн барихтай холбоотой үе шатны ажлуудыг хэрэгжүүлэх” арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажилласан бөгөөд “Төрийн аудитын тухай хууль” /шинэчилсэн найруулга/ батлагдаж 2020 оны 6 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэллээ.
..\..\WORKSHOP_2020\Presentation\Хуулийн танилцуулга (1).pptx



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/77 дугаар тушаалаар Стратегийн удирдлагын газрын захирлаар ахлуулсан “Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ын төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг ажилласан. Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд хуулийн төслийн хамт 4 сэдвээр баримт бичиг боловсруулж, 4 чиглэлээр хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсний дээр бусад 7 улс орны

төрийн аудитын дээд байгууллагын хууль тогтоомжийг судалгаанд ашиглан, шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 6 хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулахад оролцжээ.

Хуулийн төсөлд нийт 103 байгууллагаас санал авахаар хүргүүлж, хуулийн шинэчлэлийн багц 21383 хуудас тараах материал бэлтгэн түгээжээ.

Нэр	Хуудасны тоо	Хувь	Нийт хуудас
Хуулийн хавтас	295	22	6490
УИХ-ын гишүүдэд тараах материал	178	76	13528
Санал авахаар хүргүүлсэн материалын тоо:			
УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд	65	8	520
Төрийн захиргааны төв байгууллагууд	65	13	845
НИЙТ			21383

Төрийн аудитын тухай хуулийн гол зорилго нь Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх, татвар болон татварын бус орлого, байгалийн баялгийн ашиглалтаас бүрдсэн нийтийн өмчийг зохистойгоор төлөвлөх, тайлагнах, ашиглах, зарцуулах үйл ажиллагаанд тавих хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршиж байгаа бөгөөд 6 бүлэг, 43 зүйл, 225 заалттай юм.


Ажлын хэсэг	Хурлын тоо
УАГ-ын ажлын хэсгийн	12
Төсвийн байнгын хорооны	3
УИХ-ын ажлын хэсгийн	3
УИХ-ын нэгдсэн чуулган	5
НИЙТ	23

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны семинарын хөтөлбөрийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, үзэл баримтлал сэдвээр мэдээлэл хийлээ.

Бэлтгэл ажлыг сайтар хангаснаар INTOSAI-гаас баталсан “Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт”-ыг Монгол улсын “Төрийн аудит”-ын стандартаар баталгаажуулснаар 2020.01.13-ны өдрөөс MNS 6817:2020 стандартыг мөрдөж эхлэв.

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартыг үндэсний стандарт болгох ажлын хүрээнд дараах үндсэн ажлыг гүйцэтгэн бэлтгэлийг хангав.

- *Стандартыг MNS0102:2006 стандартын дагуу үндэсний стандарт болгон загварчлах, Стандартчилал хэмжил зүйн газраар хянуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэх,*
- *Стандартын талаарх саналыг Монгол Улсын УИХ-ын Тамгын газар, ТБХ, төрийн захиргааны, төрийн, төрийн бус, их, дээд сургууль, судалгааны зэрэг 21 байгууллагуудаас санал авахаар хүргүүлж, нийт 15 байгууллагаас хариу санал ирсэн.*
- *Үндэсний стандартыг Банк, санхүү, даатгалын стандартын техникийн хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, танилцуулга, илтгэл бэлтгэж хүргүүлэх,*
- *Үндэсний стандартыг Банк, санхүү, даатгалын стандартын техникийн хорооны гишүүдийн хуралд танилцуулга хийж, Техникийн хорооны 13 хүний 100 хувийн саналаар үндэсний стандартыг батлахыг дэмжсэн байна.*



INTOSAI-аас гаргасан “Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт”-ыг Үндэсний аудитын газар болон Стандарт, хэмжил зүйн газартай хамтран Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн Банк, санхүү, даатгалын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлснээр Монгол Улсын “Төрийн аудит”-ын стандарт болгон баталгаажуулж уг /MNS 6817 : 2020/ стандарт 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн албан ёсоор мөрдөж байна.



АДБОУС-ыг үндэсний стандарт болгож баталгаажуулсан нь төрийн аудитын байгууллагын бодлого, арга зүйг боловсронгуй болгох, аудитын чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хэрэглэгчдийн итгэлийг бэхжүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үүрэг хариуцлагыг тодорхой болгоход чухал алхам болж, сурталчлах ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд стандартын талаар Удирдлагын зөвлөлд зориулсан танилцуулгыг 3 дугаар сард хийв.

МУЕА-ын 2020 оны 05 дугаар 21-ний өдрийн А/46 дугаар тушаалаар Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдаж, мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан шинээр болон шинэчлэн батлах дүрэм журам, бусад баримт бичгийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталсны дагуу үе шатны ажлыг гүйцэтгэж байна.

ТАБ-ын захиргааны болон аудитын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, төлөв байдлын судалгаа болон цаашид баримтлах, хэрэгжүүлэх дүрэм, журмын боломжит хувилбарыг боловсруулах, тодорхойлох чиглэлээр хөндлөнгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийн “Ажлын даалгавар”-ыг батлуулан “Оюуны инновац” ТББ-аар гүйцэтгүүлэн байнгын хяналт тавин ажиллаж байна.

МУЕА-ын 2020 оны А/46 дугаар тушаалаар нийтэд чиглэсэн /ХЗДХЯ бүртгэх/ 8, дотоод үйл ажиллагаанд чиглэсэн 6, нууцын зэрэглэл бүхий 1 дүрэм журмыг боловсруулах төлөвлөгөө батлагдаж, түүний дагуу ажиллаж байна.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой тус хуулийн 39 дүгээр зүйлд заасан “Нөлөөллийн мэдүүлгийг шийдвэрлэх журам” болон “Аудиторын ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэх журам”, мөн “Төрийн аудитын байгууллагаас албан шаардлага хүргүүлэх, төлбөрийн акт тогтооход баримтлах журам”-ын төслийг боловсруулж дуусган хяналтад шилжүүлээд байна.

ХШҮДАГ-тай хамтран ажиллаж Төрийн аудитын байгууллагын болон бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл

ажиллагаанд дотоод аудит хийх журмын төслүүдтэй танилцаж холбогдох ажилтнууд өөрсдийн саналыг тусган журмын төслийг дээд шатны удирдлагын хяналтад шилжүүлээд байна.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Төрийн аудитын байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэв.

ҮАГ-ын бүтцийн нэгжүүдийн ирүүлсэн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд үндэслэн ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны “Ерөнхий төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг нэгтгэх ажлыг гүйцэтгэв.

Үйл ажиллагааны 2019 оны тайланг нэгтгэх бэлтгэл ажлын хүрээнд ТАБ-ын 2014-2018 оны үйл ажиллагааны тайланд харьцуулсан судалгаа хийсэн ба бүтэц, хэлбэр агуулгын хувьд өөрчлөн шинэчилсэн.

ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлангийн онцлог нь тайланд тусгагдсан аудитын тайлангийн танилцуулгыг QR кодын хамт тайлагнаж, үндсэн мэдээллийг инфографикаар тайлагналаа. Мөн тайлангийн мэдээллүүдийг дүрс тэмдэг /icon/ хэлбэрт оруулж, зурж бэлтгэж, тайланг цахим хэлбэрээр УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн.

ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны тайланг бэлтгэн гаргаж, бүтцийн нэгжүүдийн тайлан болон статистикийн мэдээллийг нэгтгэн гаргаж, явцын судалгаа хийн танилцуулж, байгууллагын албан хэрэгцээнд зориулж “ABLE” системийн файлын сан хэсэгт байршуулав.

..\..\WORKSHOP 2020\TAB 2019 оны тайлан\20200421.pptx

ТАБ-ын удирдах ажилтны семинар, зөвлөгөөний төлөвлөгөө, хөтөлбөр, илтгэлийн төсөл боловсруулж батлуулсны дээр СУГ-аас “Төрийн аудитын байгууллагын бодлого стратеги, цаашдын зорилт үйл ажиллагаа” сэдвээр мэдээлэл хийв.

..\..\WORKSHOP 2020\Presentation\Танилцуулга (1).pptx,

Судалгааны хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

Үүнд:

- МУЕА-ын 2018 оны А/235, 2020 оны А/02, А/20 дугаар тушаалаар батлагдсан журмын төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах заалтын холбогдох хэсэгт харьцуулалт хийн мэдээллээр хангаж ажиллав.
- Статистикийн мэдээллийг гаргахтай холбоотой бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн асуулт, саналд хариу өгч, мэдээллээр хангаж ажиллав.
- МУЕА-ын 2018 оны А/235 дугаар тушаалаар батлагдсан “ТАБ-ын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам”-ыг шинэчлэхтэй холбоотой мэдээлэл боловсруулах аргачлалыг боловсруулж байна.
- ТАБ-ын бүтэц, зохион байгуулалттай холбоотой судалгаа хийх зорилгоор мэдээлэл цуглуулах, судалгааны ажлыг эхлүүлээд байна.
- Төрийн аудитын шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх зорилгоор “Акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжид судалгаа хийн дүнг удирдлагад танилцуулж, дүнд үндэслэн Төрийн аудитын байгууллагаас төлбөрийн акт



тогтоох, албан шаардлага өгөх журмын төсөлд тусган хяналтын шатанд шилжүүлээ.

- ТАБ-ын хэмжээнд 2020 онд ажлын хэсэг /7/, стратегийн төлөвлөгөө, дэд хөтөлбөр /5/, төсөл, хөтөлбөр /3/, мөн хамтын ажиллагаа /4/ хэрэгжиж байна.
- Төрийн албаны зөвлөлөөс төрийн байгууллагуудын дунд зарласан “Бодлогын инновац -2020” бичил төслийн сонгон шалгаруулалтад “Төрийн аудитын сургалтын тогтолцооны цогц шийдэл-Цахим сургалт” сэдвээр төсөл бичиж хүргүүлээ.
- Төрөлжсөн аудитын газруудаас ирүүлсэн санал, судалгааг үндэслэн УАГ-аас 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн саналд үндэслэн эрэмбэлэн, хүний болон санхүүгийн нөөцийн судалгааг гаргуулан төлөвлөж ашиглалаа.

Төрийн аудитын байгууллагын 2019-2023 онд хэрэгжүүлэх Харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөөний биелэлтийг 2019 он болон 2020 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, ХШҮДАГ-т хүргүүлэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна. ..\..\..\AIT\XTOC\SUG Performance_XTOC_2020_.docx

ХТОС-ийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад энэ асуудлыг ТАБ-ын аудитын төрлөөр батлагдан гаргах журмуудад нарийвчлан тусгах шаардлагатай гэсэн санал дэвшүүлж тайланг хүргүүлэв.

АДБ-ын гүйцэтгэлийн үнэлгээний тайлангийн төсөлд олон улсын зөвлөхийн өгсөн санал болон багийн гишүүдийн ирүүлсэн тайлангийн төслийг зөвлөмжийн дагуу засвар сайжруулалт хийж тайлагнахад бэлэн боллоо.

ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилга (Аи Ди Аи), Аудитын Дээд Байгууллагуудын Азийн Байгууллага (АСОСАИ)-тай хамтран Аудитын дээд байгууллага (АДБ)-ын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий АДБ-ын “Гүйцэтгэлийн Хэмжүүрийн тогтолцоо”-нд үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт хамрагдсаны дагуу Гүйцэтгэлийн хэмжүүрийн тогтолцооны үнэлгээ, аргачлалын дагуу “Үндэсний аудитын газрын гүйцэтгэл”-д үнэлгээ хийсэн тайлангийн эцсийн төслийг бэлэн болгож Гүйцэтгэлийн үнэлгээний тайланг монгол, англи хэл дээр боловсруулж англи хэл дээрх хувилбарыг олон улсын зөвлөхөөр хараат бус чанарын хяналт хийлгэхээр илгээж /ИНТОСАИ-г хөгжүүлэх сан/, дотоод хувилбарыг бэлэн болголоо.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд төлөвлөгөөний дагуу зохих ажлыг хийж гүйцэтгэсэн байна. /ТА 9731-МОН/

- Төслийн удирдах хорооны хурал зохион байгуулагдаж, төслийн эхний хагас жилийн төлөвлөгөө, төсөв батлагдсан.
- Төслийн эхлэлийн тайлан эцэслэн төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлтийг АХБ-аар батлуулав.
- Мэдээллийн технологийн урт болон богино хугацааны дотоодын зөвлөхийн сонгон шалгаруулалт хийгдэж, гэрээг байгуулав.
- Өгөгдөлд дүн шинжилгээ хийх олон улсын зөвлөхийн сонгон шалгаруулалт хийгдэж, гэрээ байгуулав.
- УАГ-ын МТ-ийн зөвлөх багийн боловсруулсан МТ-ийн бодлогын баримт бичгүүдийг /400 хуудас/ орчуулж, олон улсын зөвлөхөд танилцуулав.
- Олон улсын болон дотоодын зөвлөхөөс УАГ-ын МТ-ийн орчинд үнэлгээ хийх ажил эхэллээ.
- Төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбогдох техник, эдийн засгийн үнэлгээний төлөвлөлтийн ажлыг эхлүүлээд байна.

Дэлхийн Банк болон Европын Холбооны итгэлцлийн сангийн санхүүжилттэй “Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх” төсөл

ТАБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцооны нөхцөл байдлын судалгааг хийж тайланг монгол, англи хэлээр бэлтгэж, стратеги, төлөвлөгөөний төслийг танилцуулав.

Иргэдийн оролцооны вэб портал, гар утасны аппликэшин хөгжүүлэх, инфографик ном боловсруулах ажлын даалгавар боловсруулж, ТАБ-ын 2019 оны үйл ажиллагааны тайлангийн график дизайны ажлыг гүйцэтгэн, төслийн хүрээнд веб портал боловсруулах, визуаль тайлан, ажлыг гүйцэтгэгч талтай 4 удаагийн уулзалт зохион байгуулсан.

Веб порталын дизайн, сайтад байршуулах 5 нэгдсэн тайлангийн загварыг төрөлжсөн аудитын газруудтай харилцан тохиролцож, тайлангийн үзүүлэлтүүдийг төрөлжсөн аудитын газрын хариуцсан албан хаагчтай ярилцан санал солилцож, эцсийн байдлаар баримт материалыг хүргүүлж ажилласан. Төрийн аудитын байгууллагын харилцагч талуудад зориулсан мэдээллийн товхимлыг бэлтгэн гаргах шаардлагын дагуу иргэд, олон нийтэд зориулсан болон төрийн байгууллагуудад хандсан танилцуулга /брошюр/-ын төслийн ажлыг дуусгаж байна. Дэлхийн банкны зөвлөхийг Монгол Улсад ирж ажиллах хугацаанд төслийн ажлын явцын талаар 2 удаагийн уулзалт хийж явц, үр дүнг хэлэлцлээ.

Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах 2020-2023 оны стратегийн төслийг боловсруулаад байна.

Дэлхийн Банк болон Европын Холбооны итгэлцлийн сангийн санхүүжилттэй Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги болон хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, түүнийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. Үүний үр дүнд иргэд, олон нийт болон бусад харилцагч талуудын төрийн аудитад итгэх итгэл сайжирч, аудитын үйл ажиллагаанд саналаа ирүүлэх, аудитын үр дүнг үзэж танилцах, үйл ажиллагаандаа хэрэглэх, улмаар аудитын мөрөөр хяналт тавих ажиллагаа сайжрах юм.



Дөрөв. Аудитыг дэмжих ажил, үйлчилгээ

Монгол Улсын Их Хурлын МҮЕА-ын 2020 оны А/23 дугаар тушаалаар УИХ-ын ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийн зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо хуулийн эрх зүйн акт болон Сонгуулийн ерөнхий хороотой хамтарсан МҮЕА-ын 2020 оны 04/А-16 дугаар шийдвэрээр аргачлалыг баталсан.

Сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоох ажлын хэсэгт СУГ-аас ажиллаж, чанарын хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд хуулийн хугацаанд тогтоож, нийтэд зарласны дээр сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачилсан зөвлөмжийг нэгтгэн /17х/ аргачлал боловсруулж, МҮЕА-ын 2020 оны А/32 дугаар тушаалаар батлуулан ажиллалаа.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, ажлын баримтад чанарын хяналт хийлгэснээр сонгуулийн хууль тогтоомжийн дагуу хийх аудит хийгдлээ.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар аудитын сэдэв болон тодотгол оруулсан асуудлыг хэлэлцэн тус байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020 оны 04 дүгээр тогтоол, Үндэсний аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан 2020 оны 05 дугаар тогтоол батлагдлаа.

Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар ТАБ-аас 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг шинэчлэн батлав.

ТАБ-аас 2021 онд гүйцэтгэх Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор батлуулах аудитын сэдэвт нийт ажилтнуудаас санал авах “Судалгааны асуулга”-ыг бэлтгэж хэрэгжүүлэн аудитын сэдэв сонгохтой холбоотой “Төрийн аудитын байгууллага аудит

хийж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий хууль тогтоомжийн судалгаа”-г нэгтгэн үйл ажиллагаандаа ашиглав.

Төрөлжсөн аудитын газар болон аймаг, нийслэл дэх ТАГ-аас авсан санал болон судалгаанд үндэслэн УАГ-аас 2021 онд гүйцэтгэх аудитын сэдвийн санал, мөн УАГ-ын 2020 оны аудитын сэдэвт тодотгол оруулах төслийн саналыг нэгтгэн танилцуулга боловсруулж тогтоолын төслийг бэлтгэн УИХ-ын Төсвийн байнгын хороонд 2020 оны 05 дугаар сарын 04-ний 1484, 1485 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Аудитын сэдвийн төлөвлөгөөнд тодотгол оруулах 2021 оны аудитын сэдэвт аймаг, нийслэл дэх төрийн аудитын газруудаас санал авч ажилласан байна.

Гүйцэтгэлийн аудитын газраас “Монгол Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т байдал хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг инфографик хэлбэрээр бэлтгүүлэн УИХ-ын Тамгын газарт 86, Төсвийн байнгын хороонд 5, ЗГХЭГ-т 5, бүх яамдад тус бүр 3, нийт 135 ширхэг тайланг тус тус хүргүүллээ.

Өмнөх оны хөрөнгө оруулалт, үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайланг хэвлүүлж түгээсэн бөгөөд цахим хэлбэрээр байгууллагын сайтад байршуулсан.



- *Арга хэмжээний хүрээнд санхүүгийн тайлангийн аудитад 2019 онд хамрагдсан 1436 байгууллагын мэдээллийг нөхөж хүргүүллээ.*
- *Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланд тэмдэглэгдсэн илрүүлэлтийг нэгтгэн судалгаанд ашиглаж байна.*

Тав. Мэдээлэл, технологийн хөгжил

ТАБ-ын мэдээллийн технологийн бодлогын баримт бичгийг боловсруулахаар 14 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх баг ажилласан бөгөөд 2020-2025 онд хэрэгжүүлэх ТАБ-ын мэдээллийн технологийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан бэлэн болгож, 2020 оны 04 сард хүлээн авч төсөлд холбогдох удирдлагын санал авч байна. Төрийн аудитын байгууллагын мэдээллийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг 3 үе шаттай хийж гүйцэтгэж байгаа бөгөөд дараах үндсэн чиглэлтэй байна.

- *ТАБ-ын мэдээллийн технологийн бодлого 2020-2025 он*
- *Төслийн техникийн тодорхойлолт*
- *Дижитал аудитын энтерпрайз архитектур*
- *Дижитал аудитын хууль, эрх зүйн зөвлөмж*
- *Аудитын цахим тайлан мэдээллийн портал системийн дизайн*

Зөвлөх баг ТАБ-ын 2020-2025 онд хэрэгжүүлэх мэдээллийн технологийн бодлогын баримт бичгийн хүрээнд мэдээллийн технологийн стратеги төлөвлөгөө, системийн техникийн тодорхойлолт, системийн архитектур дизайн зэрэг баримт бичгийг боловсруулж дуусгасан бөгөөд баримт бичгүүдийг хүлээн авах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Төрөлжсөн аудит болон Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны өнөөгийн бизнес процессыг судалж, бизнес процесс, үйл ажиллагааны дараалал, үе шат, хэрэглэгчийн эрх, үйлдлүүд, үе шатны ажлын дэс дарааллыг тодорхойлон тэдгээрт үндсэн хэрэглэгчийн шаардлагын эхний хувилбарыг гарган бичиг баримтыг бэлтгээд байна.

Аудитын үйл ажиллагаанд их өгөгдөл ашиглах, өгөгдлийн шинжилгээг хийж эрсдэл тооцох талаар түншийн үнэлгээний тайлан, гадаад орнуудын туршлагын талаарх судалгааны материалуудад үндэслэн Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээний хүрээнд судалгаа хийж, тайланг бэлтгээд байна. Судалгааны хүрээнд Гүрж болон Английн

аудитын байгууллагын мэдээллийн системийг судалж, өмнөх онд АХБ-ны төслийн хүрээнд төрийн байгууллагуудын мэдээллийн системтэй хэрхэн холбогдох шинжилгээ, судалгааг хийж дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан.

Зургаа. Аудитын стандарт, арга зүйн асуудал

Олон улсын стандартад нийцүүлэн аудитын болон үйл ажиллагааны журам, гарын авлага, заавар боловсруулах ажлын хүрээнд ТАБ-аас санхүүгийн тайланд аудит хийх журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, аргачлалыг алхам тус бүрээр боловсруулж байгаа бөгөөд АДБОУС-ыг хэрэгжүүлэх гарын авлагын орчуулгыг хянахад бэлтгэж, орчуулгын хяналтад өгөх ажлыг зохион байгуулж байна. Уг гарын авлага нь санхүүгийн аудитын заавар, аргачлал боловсруулах үндэслэл болох юм.

Санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэлийг боловсруулан хүргүүлэв.

“Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит хийх ерөнхий чиглэл”-ийг аудитад ашиглах аргачилсан зөвлөмж, нэгдсэн судалгааны маягт бэлтгэж, Санхүүгийн аудитын газар болон орон нутаг дахь төрийн аудитын газарт хүргүүлэв.


Энэхүү чиглэлийн дагуу аудитын явцад учирч болох 28 эрсдэл, горимыг холбогдох хууль эрх зүйн орчин, бусад шалгуур үзүүлэлтүүдэд хамааруулан боловсруулж, СТАУС программын эрсдэлийн санд цахим хэлбэрээр оруулав. Ингэснээр санхүүгийн тайлангийн аудитад ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

СТАУС тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг хангах асуудлыг удирдлагуудад тавьж, УЗХ-ийн шийдвэр гаргуулсан. Энэхүү шийдвэрийн дагуу СТАУС-ийн тасралтгүй хэвийн ажиллах болон хөгжүүлэлтийн асуудлыг төрийн аудитын нэгдсэн систем ашиглалтад орох хүртэлх хугацаанд өөрсдийн хүч нөөцөд тулгуурлан хийх чиглэл өгсөн.

ТАБ-аас санхүүгийн аудит хийх байгууллагын тоо, аудит хийх хэлбэрийг хянаж, нэгтгэн батлуулах ажлын хүрээнд МУЕА-ын “Албан даалгавар”-ыг хүргүүлэн гүйцэтгэлийг зохион байгуулах, аймаг, нийслэл дэх ТАГ-аас ирүүлсэн жагсаалтыг хянаж, нэгтгэн удирдлагад танилцуулан шийдвэр гаргуулах бэлтгэл ажлыг хангалаа.

Төрийн аудитын байгууллагаас шалгагдагч байгууллагад өгсөн акт, албан шаардлагын хэрэгжилт үр дүнтэй, эрх зүйн хувьд үндэслэлтэй эсэх судалгааны ажлыг дуусгаж, удирдах ажилтны семинарын үеэр танилцууллаа.

Аудитын зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, боловсронгуй болгох зөвлөмж боловсруулах судалгааны ажлыг дуусган явц, тайланг удирдлага болон Удирдах ажлын семинарын үеэр танилцуулга хийсний зэрэгцээ судалгааны ажлын тайланг эцэслэн хянаж, товхимол гарган системийн хэмжээнд түгээх нь зүйтэй гэж бэлтгэл ажлыг хангаж байна.



Гүйцэтгэлийн болон Нийцлийн аудитын журмын төслийн эцсийн хувилбарыг боловсруулж дууссан бөгөөд удирдлагын түвшинд хянуулах шатанд байна.

МУЕА-ын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/46 дугаар тушаалаар баталгаажсан “Төрийн аудитын тухай хуулийн дагуу батлах дүрэм, журам, бусад баримт бичиг боловсруулах, Удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн батлуулах ажлын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу “Гүйцэтгэлийн аудитын журам” болон “Нийцлийн аудитын журам”-ыг шинэчлэн боловсруулах хугацаа өөрчлөгдсөнтэй холбоотойгоор энэ ажил гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанаас урагшилж хийгдэж эхлээд байна.

Энэхүү журмын төслийг боловсруулах явцад нэгтгэх шаардлагатай нь харагдсан тул “Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэл, нийцлийн аудит хийх журам” нэртэйгээр нэгтгэсэн журмын төслийн эцсийн хувилбарыг боловсруулж дууссан бөгөөд удирдлагын түвшинд санал авч хянуулах шатанд байна.

Долоо. Төрийн аудитын байгууллагын сургалт, хөгжил

ТАБ-ын цахим сургалт, хөгжлийн нэгдсэн системийг боловсруулан хөгжүүлэлт хийн сургалт эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж ирсэн нь төрийн аудитын байгууллагын сургалтын тогтолцоог шинэ шатанд гаргах ажлын эхлэл боллоо.

ТАБ-ын хэмжээнд 2020 онд зохион байгуулагдах сургалтын санал, судалгааг нэгтгэж, МУЕА-ын 2020 оны А/30 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2020 оны сургалтын чиглэл, ерөнхий төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагын 2020 оны цахим сургалтын төлөвлөгөө:

№	Хичээлийн нэр	Суралцагчийн бүлэг	Кредит	Судлах улирал			
				I	II	III	IV
Ерөнхий суурь хичээл							
А.Заавал судлах							
1	Аудитад EXCEL программын хэрэглээ	Нийт аудитор	3			*	
2	Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо	Нийт албан хаагч	3				*
3	Төрийн албан хэрэг хөтлөлт	Шинэ ажилтан	3				*
Мэргэжлийн суурь хичээл							
А.Заавал судлах							
4	Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ	Шинэ ажилтан	3			*	
5	Төрийн аудиторовн ёс зүй	Нийт албан хаагч	3				*
6	Хуулийн хэрэглээ (Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга)	Нийт албан хаагч	3			*	
Мэргэжлийн гүнзгийрүүлсэн хичээл							
А.Заавал судлах							
7	Санхүүгийн аудитын мэргэжлийн арга зүй	Санхүүгийн аудитор	3				*
8	Гүйцэтгэлийн аудитын мэргэжлийн арга зүй	Гүйцэтгэлийн аудитор	3				*
9	Нийцлийн аудитын мэргэжлийн арга зүй	Нийцлийн аудитор	3				*

Төрийн аудитын стандарт MNS 6817:1-8-аар сургалтын хөтөлбөр боловсруулан онлайн сургалтын сэдвийг батлан арга зүйч менежерүүд бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд Төрийн аудитын байгууллагын 2020 оны цахим сургалтын төлөвлөгөөний дагуу “Е-хичээл”-ийн сэдэв сургалтын төлөвлөгөөг батлуулан, онлайн хичээлийг заах сэдэв, хамрах сегментийн түвшин, тооцох кр/цагийг тооцож нөхцөлийг тусган сэдвийн дагуу хөтөлбөр, танилцуулгыг бэлтгэж эхлээд байна. [..ИТМЦахим сургалт 2020-06-29.pptx](#)

I**Цахим сургалтыг НЭВТРҮҮЛЭХ үе шат (2020 он)****II****Цахим сургалтыг ӨРГӨЖҮҮЛЭХ үе шат (2021-2023 он)****III****Цахим сургалтыг ХЭВШҮҮЛЭХ үе (2024 он)****Е-Хичээлийн бэлтгэх үйл ажиллагааны хүрээнд:**

- Нийт аудиторуудад зориулсан “Аудитад excel программын хэрэглээ” хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 6 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулав.
- Шинэ аудиторуудад зориулсан “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 6-р сарын 09-ний өдөр зохион байгуулж, хамтран бэлтгэх зөвлөх багш нартай уулзалт зохион байгуулж, агуулга, сэдвийг тодорхойлох ажлыг гүйцэтгэлээ.
- Хуулийн хэрэглээ (Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга) хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлгийг 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулав.
- Цахим сургалт, хөгжлийн бодлогын хүрээнд ТАБ-ын цахим сургалтад хамрагдах албан хаагчдын судалгааг гарган ажиллав.
- Хичээлийн хөтөлбөрийг боловсруулан гаргаж, түүнд тодорхойлолт, товч агуулга, зорилго, хүлээгдэж буй үр дүн, сэдэвчилсэн төлөвлөгөөг нийт 12 сэдвээр ашиглах материалын хамт бэлтгээд байна.

ТАБ-ын цахим сургалтыг явуулахад баримтлах журмын төслийг 2 удаа хянаж холбогдох засварыг оруулснаас гадна боловсруулсан хөтөлбөрийн дагуу “Е-хичээл”-ийн багц, агуулгыг бэлтгэн сургалтын материал хүлээн авах комиссын чиг үүргийн талаар санал боловсруулан цахим сургалтын журамд тусган журмын төслийг бэлэн болголоо.

Цахим сургалтын удирдлагын мэдээллийн дэд системд үүсэх анхдагч мэдээллийн баазын бүрдүүлэлт, түүнээс хамаарсан статистик үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Статистик үзүүлэлтүүд дээр тулгуурлан цахим сургалтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулах ахлах түшмэлийн мэргэшүүлэх цахим сургалтад орон нутаг, нийслэлийн 64 ахлах аудиторыг хамруулахаар нэрсийг гарган холбогдох мэдээллийг хүргүүлэх ажлыг зохион байгуулж, нэвтрэх код болон онлайнаар явагдах нэгдсэн шалгалтын линкийг 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлж 05 дугаар сарын 07-ны өдрийн 10-12 цагт орон даяар явагдсан нэгдсэн шалгалтад бүрэн хамрууллаа.

Удирдлагын академийн Сургалтын албанаас Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан нэр бүхий 6 ахлах аудиторын сертификатыг олгуулсан бол ММНБИ-д мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах хүсэлт ирүүлсэн 32 аудиторын талаарх мэдээллийг хүргүүлж, хамтран ажиллахаар боллоо.

ТАБ-ын 2021 оны сургалт, хөгжлийн нэгдсэн үйл ажиллагаанд зарцуулах 356.9 сая төгрөгийн төсвийн төслийг боловсруулан холбогдох газарт хүргүүлэв.

Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч доктор У.Туяа нийт 14 албан хаагчдыг оролцуулсан “Насанд хүрэгчдэд чиглэсэн сургалтын онцлог, цахим сургалтын

материал боловсруулах арга зүйн зөвлөгөө өгөх сургалт”-ыг 6 дугаар сард зохион байгуулав.

ТАБ-ын ажилтнуудад зориулсан архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын талаар Архивын Ерөнхий газрын мэргэжил, арга зүйн удирдлагын газартай хамтран 6 сэдвээр цахим сургалтыг зохион байгуулахаар холбогдох материалыг хүргүүлэн бэлтгэл ажилд ороод байна.

ҮАГ-ын аудиторудад зориулсан аудитын арга зүйн сургалтын 38 цагийн хөтөлбөрийн төслийг боловсруулж саналыг БНХАУ-ын ҮАГ-т, Кувейт улсын төрийн аудитын товчоотой хамтран манай улсад зохион байгуулах газрын тосны аудит хийх арга зүйн сургалтын хөтөлбөрийн төсөл, явагдах хугацааны талаар санал хүргүүлж хугацааг тохиролцсон байна.

Найм. Бусад ажил, үйлчилгээ, дотоод үйл ажиллагаа

Үүрэг даалгавар: (Шинээр гүйцэтгэсэн болон МҮЕА, газрын захирлын шууд удирдлага дор хэрэгжүүлсэн нэмэлт ажил, үйлчилгээ)

- “ТАБ-ын цахим сургалтыг зохион байгуулах 2020 оны үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулах ажлын даалгаврын төлөвлөгөөг батлуулж, ажлын гүйцэтгэлийг Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулан хэрэгжилтийг тайлагнаж ирлээ. [PROJECT\Consultant's report.docx](#)
- Төрийн аудитын байгууллагын чадавхыг бэхжүүлэх төсөл /ТА 9731-МОН/ ([ADB-project20200610.docx](#))-ийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг хавсаргав.
- Дэлхийн Банк, Европын Холбооны итгэлцлийн сангийн санхүүжилттэй “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх” төсөл (20200610 - [SGM WB and EU project progress \(1\).docx](#))-ийн хэрэгжүүлсэн ажлын тайланг хавсаргав.
- Сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж Монгол Улсын СЕХ-ны гишүүдийн хурлаар хэлэлцүүлж, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 04, А-16 хамтарсан шийдвэрээр батлуулсан.
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.5-д заасан эрх, үүргийн хүрээнд "Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам" боловсруулан баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ.
- Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах аргачилсан зөвлөмжийг нэгтгэн 17 хуудас аргачлал боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлуулсан.
- СУГ-ын аудитын менежерүүдээс УИХ-ын 2020 оны ээлжит сонгууль болохтой холбогдуулан сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах ажлын хэсэгт Монгол Улсын Ерөнхий аудиторовын шийдвэрээр зарим ажилтнууд дайчлагдан ажиллав.
- ҮАГ-аас 2020 онд гүйцэтгэх аудитын явц байдлын судалгааг сар бүр авч байх, тус оноос эхлэн гүйцэтгэсэн аудитын тайланг УИХ-д хүргүүлэх ажлыг СУГ зохион байгуулах болсонтой холбоотой төрөлжсөн аудитын газруудад хүргүүлэх албан бичиг, холбогдох маягтын төслийг боловсруулсан.
- ҮАГ-аас 2020 онд гүйцэтгэх аудитын явц байдлын судалгааг төрөлжсөн аудитын газруудаас сар бүрийн эцэст судалгаа гаргуулан авахаар шийдвэрлэж дээд шатны удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж ирлээ.
 - Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдэв болон он дамжин гүйцэтгэж байгаа аудитын

талаар судалгаа хийж үргэлжилж байгаа аудитын судалгааг гарган удирдлагыг мэдээллээр ханган ажиллав.

- УАГ-ын Удирдлагын зөвлөлийн хуралд “ТАБ-ын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах талаар товч танилцуулга”-г бэлтгэн танилцуулж, шийдвэрлүүлэв.
 - ТАБ-аас 2020 онд гүйцэтгэх аудитын сэдэв баталсан ТБХ-ны 05 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн боловсруулахтай холбоотой НАГ, ГАГ-аас 2019 онд төлөвлөсөн хугацаа хэтэрсэн, хойшлуулсан аудитуудын хойшлуулсан, хугацаа хэтэрч он дамжин хийгдэж байгаа шалтгаан, үндэслэлийг гаргуулан авахаар дотоод албан бичиг хүргүүлсэн. Мөн ЭЗБХ-ноос хүргүүлсэн аудитын судалгааг шинэчлэн ирүүлэх талаар мэдэгдсэний дагуу тус газруудаас судалгааг авч байна.
 - Төсвийн байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолын дагуу 2019 онд гүйцэтгэх нийт аудитаас УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх, он дамжин гүйцэтгэж байгаа аудитын талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлэв.
- “Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлт гаргах” ажлын хэсгийн бүрэлдэхүүнд менежерүүд 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 21-ний өдөр хүртэл ажилласан байна.
 - “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгч /Доншен газрын тос-Монгол ХХК/ -ийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт” аудитын ажлын хэсэгт ажилласан.
 - “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ” аудитын ажлын хэсэгт орж ажиллаж ирлээ.
 - Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/14 дүгээр тушаалаар “Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан хөрөнгийн зарцуулалтад аудит хийх журам” боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байна.
 - Зарим улсын /7/ АДБ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн судалгааг хийж, танилцуулга бэлтгэн сан үүсгэв.

Дотоод ажлын хүрээнд нэмж гүйцэтгэсэн төлөвлөгөөт бус ажил, үйлчилгээ: (Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй болон дээд удирдлагын шийдвэрээр “Ажлын хэсэгт” ажилласан г.м)

- ХШҮДАГ-ын захирлын сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт ажилласан байна.
- МУЕА-ын 2020 оны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулагдсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу менежерүүд жижгүүрээр ажиллаж ирэв.
- Стратегийн удирдлагын газрын чиг үүрэг, стандарт, арга зүй хариуцсан менежерүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажил хийгдлээ.

Бусад: (Цаг үеийн нөхцөл байдал, хэрэгжсэн ажил, үйлчилгээ)

- Төрийн аудитын байгууллагын хэмжээнд мөрдөж буй бодлого стратеги төлөвлөлт, судалгаа шинжилгээ, гаднын байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө, хөтөлбөр, зохион байгуулагдсан ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын судалгаа гаргах ажлыг гүйцэтгэн, хяналт тавих ажлыг эхлүүлэв.
- СУГ-ын ажилтнуудын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 хувиар олгож байх талаар дотоод албан бичиг төлөвлөж газрын хамт олны саналыг авч МУЕА-т асуудал

тавьж шийдвэрлүүлснээр 2020.04.01-нээс онцгой нөхцөлийн нэмэгдлийг 25 хувиар олгохоор болсон. /Ж.Эрдэнэ/

- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Хүний нөөцийн аудит”-ын 5 хоногийн сургалтад П.Цэнгүүн оролцжээ.
- Стратегийн удирдлагын газрын чиг үүргийг шинэчлэн боловсруулах, стандарт арга зүй хариуцсан менежерүүдийн ажлын байрны тодорхойлолтын төслийг урьдчилсан байдлаар боловсруулан ажиллажээ.
- Өвөрхангай аймаг дахь ТАБ-д албан томилолтоор менежер Х.Баярмаа ажиллаж, сургалт зөвлөгөө, заавар өгч ажиллав.
- Өвөрхангай аймаг дахь ТАГ-ын үйл ажиллагааны статистик мэдээллийн зарим үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр бэлтгэв.
- Өвөрхангай аймаг дахь ТАГ-ын албан хаагчид болон харилцагч талуудаас авсан судалгааны үр дүнг нэгтгэв.

ҮАГ-т хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, ажлын хэсэг, дэд төлөвлөгөө, хамтран ажиллаж буй байгууллага зэргийн жагсаалтыг гаргаж судалгаа, үйл ажиллагааны тайлагналын ажилд ашиглаж байна.

Ес. Дүгнэлт

- Төрийн аудитын байгууллагын стратегийн төлөвлөгөө болон 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган биелүүлэх талаар газрын хамт олон идэвхтэй ажиллан, ажилтан бүр өөрийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хангалттай гүйцэтгэсэн байна.
- Өнгөрсөн хугацаанд Сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу дүрэм, заавар боловсруулах, дүгнэлт гаргах ажлын хэсэгт удирдлагын шийдвэрээр байгаагүй хугацаанд үр бүтээлтэй ажилласан ч газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажлын хэрэгжилт удаашрах нөхцөлийг үүсгэсний дээр цар тахлын улмаас гадагш хандсан судалгааны болон төрийн зарим байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөт ажил хойшлох болсон байна.
- Газрын төлөвлөгөөнд тусгагдсан “Хэрэгжиж буй” цөөн тооны асуудал нь үйл ажиллагааны болон төрөлжсөн аудитын чиглэлээр журам, заавар аргачлал, мөн Мэдээллийн технологийн чиглэлээр гүйцэтгэх буюу судалж шинэчлэх, сайжруулах, хөгжүүлэх, боловсруулж баталгаажуулах, үндэслэлийг нарийвчлан гаргах зэргээр ихээхэн хугацаа шаардсан ажил байна.

Өнгөрсөн хугацааны ажлын ачаалалттай байдлаас шалтгаалан бүрэн дуусгавар болоогүй болон “Хэрэгжсэн” ажлын үр нөлөөг үнэлэх, сүүлийн хагаст эхлүүлэх, мөн гүйцэтгэл тооцох ажил, үйлчилгээнд анхаарал хандуулан ажиллахаар цаашдын зорилт, анхаарах асуудлыг томъёолон ажиллаж байна.

Арав. Цаашдын зорилт, анхаарах асуудал

СУГ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт, үйл ажиллагааны дүнд үндэслэн 2020 оны сүүлийн хагаст дараах зорилт, арга хэмжээний гүйцэтгэлд гол анхаарлаа чиглүүлэх асуудал. Үүнд:

- Хууль сурталчлах болон төрийн аудитын тухайн хуулийг дагаж өөрчлөгдөх 16 дүрэм, журмын боловсруулалтын ажилд ажлын хэсгийн гишүүд болон бүтцийн нэгжүүдээс оролцох оролцоог сайжруулах.
- Аудитын бодлого, стандарт дэмжих үйлчилгээний хүрээнд Монгол Улсын Төрийн аудитын стандартыг нутагшуулах, стандартын хүрээнд уламжлалт, хосолсон, цахим сургалтын бэлтгэл ажил, зохион байгуулалт, хэрэгжилт, гүйцэтгэлд анхаарна.

- Төрийн аудитын байгууллагын мэдээллийн технологийн бодлого, стратегийн хүрээнд мөрдүүлэх баримт бичгийн төслийн боловсруулалтын чанар анхаарч, нэвтрүүлэх үе шатны ажлын эхлүүлнэ.
- Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Төрийн аудитын байгууллагын чадавхыг хөгжүүлэх” Азийн хөгжлийн банкны /ТА 9731-МОН/ болон Дэлхий банк, Европын холбооны итгэлцлийн сангийн дэмжлэгтэй “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх” төслийн үе шатны ажлын хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд анхаарч байна.
- Хамтран ажиллах төлөвлөгөө бүхий зарим төрийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулан төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарч ажиллана.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БУНДХОРОЛ

БОЛОВСРУУЛСАН:

МЕНЕЖЕР

Л.ЭРДЭНЭЧУЛУУН